

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛООР ЗАСГИЙН ГАЗАРТ ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН
2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

*/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
эрхлэх асуудлын хүрээнд/*

2020.07.22

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайлан”-г 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн ХЭГ/1503 тоот албан бичгээр Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлсэн.

“Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тайланд шинжилгээ хийж, Байнгын хорооны эрхлэх асуудал тус бүрээр ялган гаргасан болно. Шинжилгээний дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн хууль тогтоомжийн хэсэг, заалтыг хяналтаас хасах саналыг хавсаргав.

“Монгол Улсын Засгийн газарт хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ХЭСЭГ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Монгол Улсын хуулиар Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн 105 хуулийн 527 хэсэг, заалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний хэлтэс хяналтад авч, мэдээллийн санд бүртгэсэн болно.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 99 хуулийн 427 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 99 хуулийн 426 хэсэг, заалт буюу 80.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 12 /давхардсан тоогоор/ хуулийн 101 хэсэг, заалт буюу 19.2 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Харин өмнөх онуудад хяналтаас хасагдсан 1 хуулийн 1 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Хууль /давхардсан тоогоор/	Хэсэг, заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	105	527
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	99	427
	- Хяналтад байгаа	99	426
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	1	1

3	Засгийн газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	12	101
---	---	----	-----

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 99 хуулийн 427 хэсэг, заалтаас давхардсан тоогоор 67 хуулийн 250 хэсэг, заалт буюу 58.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 28 хуулийн 54 хэсэг, заалт буюу 12.6 хувь нь хэрэгжих шатанд, 18 хуулийн 36 хэсэг, заалт буюу 8.4 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 23 хуулийн 29 хэсэг, заалт буюу 6.8 хувь нь хэрэгжээгүй, 25 хуулийн 58 хэсэг, заалт буюу 13.6 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

2.2. Монгол Улсын хуулиар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд тусгайлан үүрэг өгсөн хэсэг, заалтын хэрэгжилт

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 9 хуулийн 79 хэсэг, заалтыг Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 9 хуулийн 38 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлж, хяналтад байгаа 1 хуулийн 41 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 9 хуулийн 38 хэсэг, заалтаас давхардсан тоогоор 7 хуулийн 31 хэсэг, заалт буюу 81.6 хувь нь бүрэн хэрэгжсэн, 2 хуулийн 3 хэсэг, заалт буюу 7.9 хувь нь хэрэгжих шатанд, 1 хуулийн 2 заалт буюу 5.3 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 хуулийн 1 заалт буюу 2.6 хувь нь хэрэгжээгүй, 1 хуулийн 1 заалт буюу 2.6 хувь нь үнэлэх боломжгүй байна.

	Хууль /давхардсан тоогоор/		Хэсэг, заалт	
	Тоо	Тоо	Тоо	Хувь
Хяналтад авсан	9	79		100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	9	38		48.1
Үүнээс:				
- бүрэн хэрэгжсэн	7	31		81.6
- хэрэгжих шатанд	2	3		7.9
- хэрэгжилт хангалтгүй	1	2		5.3
- хэрэгжээгүй	1	1		2.6
- үнэлэх боломжгүй	1	1		2.6

2.3. Мэдээнд гарсан зөрчил

Цөмийн энергийн тухай хуулийн 33.4-т заасан “Цөмийн материалыг бүртгэх, хянах журмыг Засгийн газар батална.”, 42.4-т заасан “Цөмийн төхөөрөмж, цацрагтай холбогдолтой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын аюулгүй ажиллагааны дүрмийг Засгийн газар батална.” гэсэн заалтуудын хэрэгжилт 2019 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжих шатанд буюу 70 хувийн хэрэгжилттэй байсан бол 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн хэрэгжилттэй болж өөрчлөгдсөн байна.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасан “Монгол Улсын хилийг хамтран шалгах Монголын талын бүрэлдэхүүнийг Засгийн газар

томилно” гэсэн заалтын хэрэгжилтийг үнэлэх боломжгүй гэж тайлагнаж ирүүлсэн бол Дипломат албаны тухай хуулийн 15.6-т заасан “Энэ хуулийн 15.5-д заасны дагуу дипломат албанд ажиллуулах журмыг гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. /15.5.Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төр, засгийн бусад байгууллагатай тохиролцон тодорхой мэргэжлийн төрийн албан хаагчийг тусгайлан бэлтгэж дипломат албанд авч ажиллуулж болно./” гэсэн заалтын хэрэгжилтийг Гадаад харилцааны яамнаас тайлан ирүүлээгүй 0 хувьтай үнэлж ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй хуулийн хэсэг, заалт:

№	АБГБХ-ны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд тусгайлан үүрэг өгсөн хуулийн нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй хуулийн хэсэг, заалт
1	Олон улсын гэрээний тухай /Шинэчилсэн найруулга 2016.12.01/	9.4; 10.1; 10.2; 10.3; 11.1; 11.2; 11.4; 12.1; 12.2; 12.3; 13.1; 13.2; 15.1; 16.1; 16.2; 16.3; 17.1; 17.3; 19.3; 20.1; 20.2; 20.3; 20.4; 21.1; 21.4; 21.5; 21.6; 22.1; 23.1; 24.1; 24.2; 24.3; 24.4; 24.5; 24.6; 25.1; 25.3; 25.4; 25.5; 32.1; 34.2 дэх хэсэг, заалт
Нийт 1 хуулийн 41 хэсэг, заалт		

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг өгсөн нийт 70 тогтоолын 238 заалтыг хяналтад авсан.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 55 тогтоолын 171 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 38 тогтоолын 118 заалт буюу 49.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, давхардсан тоогоор 40 тогтоолын 120 заалт буюу 50.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан 24 тогтоолын 53 заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Тогтоол /давхардсан тоогоор/	Заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	70	238
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	55	171
	- Хяналтад байгаа	38	118
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	24	53
3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	40	120

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн Улсын Их Хурлын 38 тогтоолын 118 заалтаас давхардсан тоогоор 30 тогтоолын 74 заалт буюу 62.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 11

тогтоолын 31 заалт буюу 26.3 хувь нь хэрэгжих шатанд, 7 тогтоолын 9 заалт буюу 7.6 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 0.9 хувь нь хэрэгжээгүй, 3 тогтоолын 3 заалт буюу 2.5 хувь нь хэрэгжих хугацаа болоогүй байна.

3.2. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Улсын Их Хурлын 4 тогтоолын 15 заалтыг Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтад авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын 3 тогтоолын 6 заалт буюу 40.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, давхардсан тоогоор 2 тогтоолын 9 заалт буюу 60.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 3 тогтоолын 6 заалтаас 2 тогтоолын 2 заалт буюу 33.3 хувь нь бүрэн хэрэгжсэн, 2 тогтоолын 4 заалт буюу 66.7 хувь нь хэрэгжих шатанд байна.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	УИХ-ын тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтад авсан	4	15	100
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	3	6	40.0
Үүнээс:			
- Бүрэн хэрэгжсэн	2	2	33.3
- Хэрэгжих шатанд	2	4	66.7

3.3. Мэдээнд гарсан зөрчил

Тус байнгын хорооны 2016 оны “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2016 оны 34 дүгээр тогтоолын 1.4-т заасан “Энэ тогтоолын 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн ордонд байрладаг байгууллагуудыг шилжүүлэн байрлуулах саналыг боловсруулж 2016 оны 4 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах” гэсэн заалтын хэрэгжилтийг 2019 оны эхний хагас жилийн байдаар 100 буюу бүрэн хэрэгжсэн гэсэн үнэлгээтэй ирж байсан бол 2019 оны жилийн эцсийн байдлаар “Төрийн ордны барилгын чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж холбогдох баримт бичгийн хамт 2018 онд УИХ-д танилцуулсан. Мөн “Төрийн ордны барилгын чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хамт төрийн ордны барилгыг шинээр барих болон хуучин барилгыг хүчитгэхэд шаардлагатай судлагаа, тооцоо, түүнчлэн Төрийн ордонд байрладаг байгууллагуудыг шилжүүлэх саналыг дахин боловсруулж шаардлагатай санхүүжилтийн тооцооны хамт Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 21-ний хурлаар хэлэлцүүлсэн. Дээрх судалгаа тооцоонд үндэслэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2020 оны төсвийн тухай хуулинд төрийн ордны барилгыг хүчитгэх, шинээр барих барилгын зураг төслийн санхүүжилтийг тусган Сангийн яаманд хүргүүлсэн” гэж тайлагнаад хэрэгжилтийн хувийг бууруулан үнэлж 70 буюу хэрэгжих

шатанд болгон өөрчилж ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй Улсын Их Хурлын тогтоолын заалт:

№	АБГБХ-ны эрхлэх асуудлын хүрээн дэх тогтоолын нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй тогтоолын заалт
1	Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай /2015.06.19 №60/	1.3; 1.5 дэх заалт
2	Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай /2019.11.21 №92/	1; 2; 3; 4; 5; 6; 7 дэх заалт
Нийт 2 тогтоолын 9 заалт		

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООДЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

4.1. Байнгын хороодын тогтоолын хэрэгжилт

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний хэлтэс 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хороодоос Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн нийт 99 тогтоолын 673 заалтыг мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 82 тогтоолын 420 заалт буюу 62.4 хувийн хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн нь бүгд хяналтанд байх заалтууд байна. Давхардсан тоогоор 47 тогтоолын 253 заалт буюу 37.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

		Тогтоол /давхардсан тоогоор/	Заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	99	673
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	82	420
	- Хяналтад байгаа	82	420
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	-	-
3	ЗГХЭГ-аас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	47	253

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 82 тогтоолын 420 заалтаас давхардсан тоогоор 65 тогтоолын 252 заалт буюу 60.0 хувь нь бүрэн хэрэгжсэн, 47 тогтоолын 100 заалт буюу 23.8 хувь нь хэрэгжих шатанд, 20 тогтоолын 26 заалт буюу 6.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 11 тогтоолын 28 заалт буюу 6.7 хувь нь хэрэгжээгүй, 12 тогтоолын 14 заалт буюу 3.3 хувь нь үнэлэх боломжгүй гэсэн мэдээ ирүүлсэн байна.

4.2. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг өгсөн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 11 тогтоолын 47 заалтыг Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хяналтад байгаа тус Байнгын хорооны 8 тогтоолын 35 заалтын хэрэгжилтийн мэдээг

ирүүлж, давхардсан тоогоор 5 тогтоолын 12 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 8 тогтоолын 35 заалтаас давхардсан тоогоор 3 тогтоолын 19 заалт буюу 54.3 хувь нь бүрэн хэрэгжсэн, 7 тогтоолын 11 заалт буюу 31.4 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 11 заалт буюу 2.9 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 4 заалт буюу 11.4 хувь нь хэрэгжээгүй байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	АБГББХ-ны тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
<i>Хяналтад авсан</i>	11	47	100.0
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	8	35	74.5
Үүнээс:			
- <i>Бүрэн хэрэгжсэн</i>	3	19	54.3
- <i>Хэрэгжих шатанд</i>	7	11	31.4
- <i>Хэрэгжилт хангалтгүй</i>	1	1	2.9
- <i>Хэрэгжээгүй</i>	1	4	11.4

4.3. Мэдээнд гарсан зөрчил

Тус байнгын хорооны Чиглэл өгөх тухай /2016.11.23 №09/ тогтоолын 1, 2, 3, 4 дүгээр заалтын хэрэгжилтийг Гадаад харилцааны яамнаас тайлан ирээгүйтэй холбоотойгоор хэрэгжээгүй буюу 0 хувь гэж үнэлж ирүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай /2018.05.09 №05/13/ тогтоолын 1.1 дэх хэсэгт заасан “Газар хөдлөлтийн гамшигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолын биелэлт хангагдаагүй арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх” гэсэн арга хэмжээний хэрэгжилтийг “Газар хөдлөлтийн гамшигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоол, Засгийн газрын 2016 оны 282 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-ний хүрээнд 2020 онд 4 чиглэлээр 40 арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэж тайлагнаад хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувь гэж үнэлж ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй Байнгын хорооны тогтоол, хуралдааны тэмдэглэлийн заалт:

№	АБГББХ-ны тогтоолын нэр, хуралдааны тэмдэглэл огноо, дугаар	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй Байнгын хорооны тогтоолын болон хуралдааны тэмдэглэлийн заалт
1	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай /2017.01.25 №04/	1.3; 1.4 дэх заалт
2	Чиглэл өгөх тухай /2017.02.10 №05/	1.1; 1.2; 1.3; 1.4; 1.5; 1.6 дахь заалт
3	Чиглэл өгөх тухай /2017.02.24 №06/	1.10 дахь заалт
4	Чиглэл өгөх тухай /2017.06.30 №07/	1.1; 1.2 дахь заалт
5	Жагсаалт шинэчлэн батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 326 дугаар тогтоол	1 дэх хэсэг

болон түүний хавралтын нэрийг өөрчлөх талаар Засгийн газарт чиглэл өгөх хуралдааны тэмдэглэл /2019.12.05 №24/	
Нийт 4 тогтоолын 11 заалт, 1 хуралдааны тэмдэглэлийн 1 заалт	

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн буюу 100 хувь гэж үнэлэн ирүүлсэн Монгол Улсын 7 хуулийн 31 хэсэг, заалтыг хасах санал ирүүлснээс 3 хуулийн 6 заалтыг хяналтад үлдээхээр, Улсын Их Хурлын 2 тогтоолын 2 заалт хасах санал ирүүлснээс 1 тогтоолын 1 заалтыг хяналтад үлдээхээр, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 3 тогтоолын 19 заалтыг хяналтаас хасах санал ирүүлснээс 3 тогтоолын 10 заалтыг хэрэгжилт хангалтгүй гэж үнэлэн хяналтад үлдээж, хасах саналтай бусад заалтуудыг хавсралтаар хүргүүлэв.

ЗУРГАА. САНАЛ

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль тогтоомжийн хэрэгжилтийг тооцохдоо хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулж тайлбарлаагүй орхигдуулсан, тус Байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах 1 хуулийн 41 хэсэг, заалт, Улсын Их Хурлын 2 тогтоолын 9 заалт, Байнгын хорооны 5 тогтоолын 12 заалтын хэрэгжилтийн мэдээг бүрэн ирүүлээгүй болно.
2. 2019 оны эхний хагас жилийн мэдээтэй харьцуулахад хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувийг бууруулж үнэлэх, хяналтанд авсан зарим заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлэхгүй орхигдуулах зэрэг зөрчил гарч байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ИЙН ЖАГСААЛТ
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Хуулийн нэр, огноо	Агуулга	Хэрэгжилт
1	Цөмийн энергийн тухай 2009-07-16	39.3. Цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх журмыг Засгийн газар батална.	Цацраг идэвхт материалыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны дүрмийн төслийг ЦЭК-ын цахим хуудас, фэйсбүүкд олон нийтээс санал авахаар байршуулсан. Мөн Ажлын албаны санал авах тухай 1/208 тоот албан бичгийг 48 байгууллагад хүргүүлж, ирүүлсэн саналыг нэгтгэн 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Цацрагийн аюулгүйн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, зөвлөмж гаргуулсан. -Цацраг идэвхт материалыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны дүрмийг Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 243 дугаар тогтоолоор батлуулсан.
2	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай (шинэчилсэн найруулга) 2013-01-31	10.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулах дахь аюулгүй ажиллагааны журмыг геологи, уул уурхайн болон батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн хяналтын төв байгууллагатай хамтран батална.	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг Засгийн газар батлахаар заасан. Уг аюулгүй ажиллагааны дүрэмд тэсрэх материалын агуулахын аюулгүй байдлыг нэг бүлэгт тусган оруулан шинэчлэн боловсруулж Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлуулсан. Мөн Улсын Их Хурлын 2020.01.30-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан. Энэхүү хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр уг асуудлыг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмээр зохицуулахаар тусгасан.
3	Гамшгаас хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ 2017.02.02	11.3.Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэрийг дараахь албан тушаалтан гаргана. 11.3.3. Улсын хэмжээнд, эсхүл аймаг, нийслэл болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрт үүссэн буюу үүсч болзошгүй гамшгийн үед тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар.	Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоолоор шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрөөс мөн оны 3 дугаар сарын 2-ны өдөр хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн бөгөөд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг Засгийн газрын 2020 оны 64, 102 тогтоолоор тус тус сунгав. Засгийн газрын 2020 оны 102 дугаар тогтоолын 3 дахь заалтаар Оросын Холбооны Улсаас зорчин ирэх Монгол Улсын иргэдийг 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 20:00 цагаас 3 дугаар сарын 28-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд зөвхөн Алтанбулаг боомтоор улсын хилээр нэвтрүүлсний

			<p>үндсэн дээр хилийн бүх боомтоор нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл түр зогсоов.</p> <p>Засгийн газрын 2020 оны 39 дүгээр тогтоолын 1.1 дэх заалтаар Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн агаарын зам, төмөр зам, авто замын бүх боомтоор Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэд болон тус улсаас ирж байгаа гуравдагч орны иргэн, харьяалалгүй хүнийг 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 3 дугаар сарын 2-ны өдөр хүртэлх хугацаанд Монгол Улс руу нэвтрүүлэх хөдөлгөөнийг зогсоосон.</p> <p>Засгийн газрын 2020 оны 147 дугаар тогтоолоор дээр заагдсан хугацааг 2020 оны 5 дугаар сарын 31-ний дуустал тус тус сунгав.</p>
		20.4. Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг хуулийн этгээдэд нөхөн олгох, нэрвэгдэгсдэд дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.	“Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг хуулийн этгээдэд нөхөн олгох, нэрвэгдэгсдэд дэмжлэг үзүүлэх журам”-ыг Засгийн газрын 2019 оны 133 дугаар тогтоолоор батлуулав.
		36.1.3. Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зардал, урамшуулал авах.	“Гамшгаас хамгаалах сайн дурны хэсгийн зардал урамшуулал олгох журам”-ыг Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 38 дугаар тушаалаар батлуулав. 2020 оны 01 дүгээр улиралд Засгийн газрын нөөц сангаас 1218,9 сая төгрөг, Улсын онцгой комиссоос 150,0 сая төгрөгийг авч цар тахлын үед хэрэглэх хувийн хамгаалах багаж, хэрэгсэлд, 52,7 сая төгрөгийг онцгой нөхцөлд ажилласан ажилтнуудын урамшуулал, хоолны зардалд тус тус зарцуулаад байна.
4	Олон улсын гэрээний тухай /Шинэчилсэн найруулга/ 2016.12.01	9.2. Энэ хуулийн 8.1.3-т заасан заавал соёрхон батлах хоёр болон олон талт олон улсын гэрээ байгуулах саналыг гадаад харилцааны болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. /8.1.3.Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээ;/	Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээ байгуулах асуудлыг тухай бүр холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас санал авахаар ирүүлсний дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам судалж санал өгсөн. Тухайлбал, Олон улсын эрүүгийн шүүхийн дархан эрх болон эрх ямбын тухай хэлэлцээрийг соёрхон батлах; Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн конвенцийн “Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай” Монреалын протоколын Кигалийн нэмэлт өөрчлөлтөд нэгдэн орох; Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр байгуулахад холбогдох саналыг өгч тохиролцсон болно.

5	Монгол Улсын хилийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2016.12.28	5.4. Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг Засгийн газар хариуцна.	Монгол Улсын Их Хурлын 2002 оны 20 дугаар тогтоолоор “Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ыг баталж, хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Хил хамгаалах байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа бодлогын баримт бичгийн хүрээнд хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэний үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, хэрэгжилтийг хангаж байна.
		14.1. Улсын хилийн дэглэмийн эрх зүйн үндсийг Улсын Их Хурал хуулиар тодорхойлж, Засгийн газар хил залгаа улстай байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээгээр улсын хилийн дэглэмийг тогтооно.	Монгол Улсын хилийн тухай хуулийн 2 дугаар бүлэгт Улсын хилийн дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлсон. Улсын хилийн дэглэмийг Монгол-Орос улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн гэрээ, Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын 2010 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн гэрээгээр тус тус тогтоосон.
		16.2. Агаарын хөлөг нь улсын хилийн тогтоосон агаарын хаалгаар нэвтэрч, зөвшөөрсөн агаарын замаар нисч, зөвхөн хилийн боомт бүхий нисэх буудалд бууж, хөөрөх бөгөөд үүнээс өөр газраар улсын хил нэвтрэх, буух, хөөрөх асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.	Монгол Улсын хилд тогтоосон агаарын 15 хаалгаар Олон Улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу агаарын хөлгийг нэвтрүүлж байна. 2020 оны эхний 5 сарын байдлаар 11 орны 1183 агаарын хөлгийг улсын хилээр нэвтрүүлсэн.
		21.2. Хүн, мал, амьтан, ургамлын халдварт өвчин Монгол Улсын болон хил залгаа улсын нутагт тархах аюулыг хязгаарлах зорилгоор өвчин гарсан голомтын хэсэгт улсын хил дээр зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр зогсоох, хязгаарлах, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.	1. Коронавируст халдвар (COVID-19) БНХАУ, БНСУ, Япон улсад дэгдэлт хэлбэрээр улмаар Ази, Европын орнуудад тархсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын “Бэлэн байдлын зэрэгт шилжих тухай” 2020 оны 62 дугаар тогтоол, ДЭМБ-аас 2020 оны 03 сарын 11-ний өдөр цартахал гэж зарласантай холбогдуулан УОК-ын шийдвэрээр улсын хилээр зорчигчдын хөдөлгөөнийг хязгаарлаж, ачаа тээвэрлэлт онцгой горимоор явагдаж, зөвхөн улс хоорондын ачаа тээврийн жолооч нар хөдөлгөөнд оролцож байна. Коронавируст халдвараас сэргийлэх хариу арга хэмжээ авах бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд улсын хилээр нэвтрэн орж ирсэн нийт 63517 тээврийн хэрэгсэл (онгоц 280, 2610 галт тэрэг, 1157 суудлын машин, 185 автобус, 59285 ачааны машин), 183960 (агаараар 37025, хуурай замаар 146908) зорчигчдод эрүүл мэндийн хяналт тавьж, 5204 тохиолдлыг /460 сэжигтэй болон 4744 ажиглалтад авсан/ илрүүлж, ХӨСҮТ болон бусад аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, сувилалд шилжүүлсэн. 2. БНХАУ-д өндөр хоруу чанартай шувууны томуу өвчний дэгдэлт гарч Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын өвчин гарсан бүс нутгаас шувуу, үржлийн өндөг, шувууны мах, хүнсний өндөг, тэжээлийн импортыг хязгаарлах тухай 2020 оны 02-р сарын 07 өдрийн А-45 дугаарт тушаал гарсантай холбогдуулан тухайн бүс нутгаас холбогдох бүтээгдэхүүнийг хилийн боомтоор нэвтрүүлэхгүй байх, олгосон гэрчилгээг хүчингүй болгох, шинээр олгохгүй байх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

		3. Монгол Улсаас гадаад улс орнуудад мах, махан бүтээгдэхүүн экспортлох асуудлыг коронавирусын халдварын тархалт буурах болон улсын онц байдал тогтоосон хугацаа хэрэгжиж дуусах хүртэл түр хугацаагаар зогсоосон шийдвэрийг ХХААХҮЯ-аас 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 01/647 дугаар албан бичгээр ирүүлсний дагуу мах, махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээг олгохгүй байгаа болно.
	26.2.2. Улсын хилийн зурваст хил хамгаалалтын зориулалттайгаас бусад барилга байгууламж барих, үйл ажиллагаа явуулах, газар ашиглах асуудлыг Засгийн газар шийдвэрлэх;	Монгол Улсын “Хилийн тухай хууль” 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээс хойш хилийн зурваст хил хамгаалалтын зориулалттайгаас бусад барилга байгууламж барих, үйл ажиллагаа явуулах, газар ашиглах зөвшөөрлийг Засгийн газрын шийдвэрээр 3 аймгийн 8 сумын нутаг дэвсгэрт 10 аж ахуйн нэгжид ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны чиглэлээр олгосон.
	27.2. Хилийн боомтын төрөл, горим, зэрэглэлийг Засгийн газар тогтооно.	Хилийн боомтуудын төрөл, горим, зэрэглэлийг тухайн боомтыг анх байгуулахад тогтоодог ба Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Олон улсын нисэх буудлуудын нэрийг өөрчлөх, тэдгээрийн ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 455 дугаар тогтоолоор “Чингис хаан”, “Буянт-Ухаа” хилийн боомтын зэрэглэл, төрөл, горимыг тогтоосон.
	28.2. Хилийн боомтыг түр хаах, түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг зогсоох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.	Шинэ коронавирус /Covid-19/-ийн тархалттай холбогдуулан Засгийн газрын 2020 оны 39 дүгээр тогтоолоор Монгол, Хятадын хилийн Даян-Хуньшанзюй, Байтаг-Улиастай, Бургастай-Лаомемяо, Сүмбэр-Рашаан, Хавирга-Архашаат боомтуудыг түр хааж, нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2020 оны 05 дугаар сарын 31-нийг хүртэл түр зогсоосон.
	29.2. Хилийн боомтын үндэсний зөвлөл нь улсын хил хамгаалалтын, санхүүгийн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хилийн хяналтын байгууллага, худалдаа аж үйлдвэрийн танхим, ложистикийн холбооны төлөөллөөс бүрдэх бөгөөд хилийн боомтын үндэсний зөвлөлийн дарга нь санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 93 дугаар тогтоолоор Хилийн боомтын үндэсний зөвлөлийг 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Сангийн сайдын ахалсан Боомтын үндэсний зөвлөл 2020 оны 1-р улиралд 2 удаа хуралдсан ба энэ хурлаар Буянт-ухаа боомтыг Хөшигийн хөндийн шинэ нисэх буудалд нүүлгэн шилжүүлэх асуудлыг хэлэлцэж ЗГ-ын хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлэхээр тохирсон.
	29.3 Хилийн боомтын үндэсний зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална.	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 139 дүгээр тогтоолоор “Хилийн боомтын үндэсний зөвлөлийн дүрэм”-ийг баталж, албанд мөрдөж байна.
	33.2. Бүсчилсэн хил хамгаалалттай уялдуулан хилчний хилийн нэмэгдэл, цалин, хангамж, материал хэрэгслийн хангалтын норм, хэмжээг Засгийн газар тогтооно.	Монгол Улсын Засгийн газрын 2012 оны н/110 дугаар тогтоолоор баталсан “Бүсчилсэн хил хамгаалалт” хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын 2017 оны 173 дугаар тогтоолоор “Хилийн отряд, заставын зэрэглэл”, 174 дүгээр тогтоолоор “Хилийн цэргийн алба хаагчдын дүрэмт хувцас болон хэрэглэлийн норм, эдэлгээний хугацаа, хүнсний хангамжийн хэмжээ, хилийн нэмэгдэл олгох журам”-ыг тус тус баталж, албанд мөрдөж байна.

	<p>34.3. Хилийн цэргийн анги, салбарын тоо, байршил, зэрэглэлийг хил залгаа улстай тэгш эрхтэй харилцан ажиллаж, улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах эрх ашигт нийцүүлэн тэдгээрийн хилийн анги, салбартай харьцангуй ижил хэмжээнд байх зарчим баримтлан Засгийн газар тогтооно.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн “Хилийн отряд, заставын зэрэглэлийг тогтоох тухай” мн/173 дугаар тогтоолоор хилийн цэргийн анги, салбарын зэрэглэлийг тогтоосон.</p>
	<p>34.4. Улсын хил хамгаалах байгууллага нь бэлгэ тэмдэгтэй байна. Бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журмыг улсын хил хамгаалалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 283 дугаар тушаалаар “Хил хамгаалах байгууллагын бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журам”-ыг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>
	<p>38.5. Улсын хил хамгаалах байгууллагад гэрээт хилчний алба хаах журмыг Засгийн газар батална.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 11 дүгээр тогтоолоор “Цэргийн гэрээт алба хаах журам”-ыг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 552 иргэн сайн дурын үндсэн дээр гэрээ байгуулан гэрээгээр алба хааж байна.</p>
	<p>38.7. Улсын хил хамгаалах байгууллагын дүрэмт хувцасны загвар, хэрэглэх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч, эдэлгээний хугацааг Засгийн газар, хангалтын зааврыг улсын хил хамгаалах байгууллагын дарга батална.</p>	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 81 дүгээр зарлигаар “Хил хамгаалах байгууллагын цэргийн албан хаагчдын дүрэмт хувцас хэрэглэлийн загвар”-ыг, Засгийн газрын 2017 оны 174 дүгээр тогтоолоор “Хилийн цэргийн алба хаагчдын дүрэмт хувцас болон хэрэглэлийн норм, эдэлгээний хугацаа”-г, Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2018 оны А/151 дүгээр тушаалаар “Хилийн цэргийн алба хаагчдын хувцас хэрэглэлийн хангалтын заавар”-ыг тус тус баталж, албанд мөрдөж байна.</p>
	<p>39.5. Хилийн салбар, харуулд алба хааж байгаа хилчин хүнсний хангамжаар хангагдах бөгөөд хүнсний хангамжийн хэмжээг Засгийн газар тогтооно.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 174 дүгээр тогтоолын дагуу Хилчдийн хүнсний нормыг баталж, ЦАХ-дад 25 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр хангаж байна.</p>
	<p>41.4. Тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх зааврыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн, улсын хил хамгаалалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/160 дугаар тушаалаар “Хил хамгаалах байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх заавар”-ыг баталж, албанд мөрдөж байна.</p>
	<p>47.2. Албаны нохойг бэлтгэх, ашиглах, хамгаалах журмыг улсын хил хамгаалалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/30 дугаар тушаалаар “Албаны нохойг бэлтгэх, ашиглах, хамгаалах журам”-ыг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>

6	<p>Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2019.10.10</p>	<p>11.4. Зөвлөлийн ажиллах журам, ажлын албаны бүтэц, орон тоог Засгийн газар, Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Ерөнхий сайд Тагнуулын ерөнхий газрын даргын саналыг үндэслэн батална.</p>	<p>Терроризмтой тэмцэх зөвлөлийн ажиллах журам, ажлын албаны бүтэц, орон тоог Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 460 дугаар тогтоолоор, Терроризмтой тэмцэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг Ерөнхий сайдын 2020 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн 02 дугаар захирамжаар тус тус баталсан.</p>
		<p>23.2. Хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалт батлах, жагсаалтаас гаргах, түүнийг хянах, жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хөрөнгийг царцаах, эрхийг түр хязгаарлах, жагсаалттай холбоотой гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх, гуравдагч этгээдийн хөрөнгийг тусгаарлах харилцааг зохицуулсан журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын саналыг үндэслэн Засгийн газар батална.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 464 дүгээр тогтоолоор “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Журам батлагдсантай холбогдуулан Тагнуулын ерөнхий газрын даргын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны аргачлал”-ыг баталсан.</p> <p>Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах хүрээнд энэ төрлийн гэмт хэрэгтэй холбогдуулан хураасан хөрөнгө, орлогыг тодорхой зориулалтаар ашиглаж болох эсэхийг судалж, шаардлагатай хууль, эрхзүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр холбогдох санал дүгнэлтийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Сангийн сайдын 2020.03.25-ний 65 тоот тушаалаар батлагдан холбогдох хууль, журамд оруулж болох өөрчлөлтийн саналыг боловсруулан ажиллаж байна. “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ыг Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 464 дүгээр тогтоолоор баталсан. Тус журмаар хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалт батлах, жагсаалтаас гаргах, түүнийг хянах, жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хөрөнгийг царцаах, эрхийг түр хязгаарлах, жагсаалттай холбоотой гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх, гуравдагч этгээдийн хөрөнгийг тусгаарлах харилцааг зохицуулсан.</p>

Нийт 6 хуулийн 25 хэсэг, заалт

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭН ДЭХ
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ЫН ЖАГСААЛТ
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Агуулга	Хэрэгжилт
1.	Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2018.06.29 №73	1.3 Дамжин өнгөрөх тээвэр, угтуулан тавих нөхцөл, урьдчилгаа төлбөр, боомт ашиглалт, дэд бүтцийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, борлуулалтын нөхцөлийн талаар хөрш орнуудтай хэлэлцээ хийж хэрэгжүүлэх.	2018 оны 01 дүгээр сард ОХУ-ын Тээврийн яамнаас Монгол-Оросын Засгийн газар хоорондын “Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцлийн тухай хэлэлцээр”-ийн эцэслэн тохиролцсон төсөл дээр нэмэлт өөрчлөлт оруулах санал ирүүлсний дагуу уг төслийг Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн тухай ЗГ-ын хуралдааны 2018.02.14-ний өдрийн 9 дүгээр тэмдэглэл гарсан. Түүнчлэн Оросын Холбооны Улсын Ерөнхий сайдын 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 268 дугаар захирамж гарч, уг хэлэлцээрийн төслийг дэмжин, түүнд гарын үсэг зурах эрх Оросын Холбооны Улсын Тээврийн сайдад олгогдсон. Хэлэлцээрт Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, ОХУ-ын Тээврийн сайд Е.И.Дитрих нар 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдөр гарын үсэг зурсан. Уг хэлэлцээрийг Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 203 тоот тогтоолоор батлуулсан.
Нийт 1 тогтоолын 1 заалт			

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭН ХЭРЭГЖСЭН,
ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ТОГТООЛ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ЫН ЖАГСААЛТ
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Агуулга	Хэрэгжилт
1	<p>Чиглэл өгөх тухай 2017.02.24 №06</p>	<p>1.1. Батлан хамгаалах салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд “Орон нутгийн хамгаалалтын тухай” хуулийн төсөл болон бусад шаардлагатай хуулийн төслүүдийг яаралтай боловсруулан, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;</p> <p>1.5. “Монгол Улсын Батлан хамгаалах тухай”, “Зэвсэгт хүчний тухай” хуульд батлан хамгаалах үйл ажиллагаа, Зэвсэгт хүчнийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр заасны дагуу цэргийн алба хаагчдын хувцас, хичээл сургуулийн зардлыг “Зэвсэгт хүчний хөгжлийн сан”-гаас санхүүжүүлж байгааг зогсоон 2017 оны төсвийн тодотголоос эхлэн Батлан хамгаалахын сайдын төсвийн багцад суулган санхүүжүүлж эхлэх;</p> <p>1.6. Батлан хамгаалах салбарын гадаад хамтын ажиллагааны өнөөгийн хүрсэн түвшинг хадгалах, цаашид өргөжүүлэх зорилгоор гадаад арга хэмжээний зардлыг төсвийн багцад зохих хэмжээгээр суулган санхүүжүүлэх талаар арга хэмжээ авах;</p>	<p>Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар “Орон нутгийн хамгаалалтын тухай” хууль батлагдсан.</p> <p>2016 оны 9 дүгээр сард Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний нормын хувцас, хэрэгсэл, сургалт дадлагын зардал”-ыг Зэвсэгт хүчний хөгжлийн сангаас санхүүжүүлэх зардлыг хүчингүй болгож, 2018 оноос эхлэн улсын төсвөөс санхүүжүүлж байна.</p> <p>Батлан хамгаалах салбарын гадаад хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд өргөжихийн хэрээр түүний төсвийн зардал жилдээ 300-400 сая төгрөгт хүрч улсын төсвийн урсгал зардлын төсвөөр санхүүжүүлж ирсэн. 2016-2017 онд улс орны эдийн засаг, төсвийн хүндрэлээс шалтгаалж Батлан хамгаалахын сайдын төсвийн багцад гадаад арга хэмжээ, зочин төлөөлөгч хүлээн авах зардал батлагдаагүй тул хүрсэн түвшинг хадгалах үүднээс Батлан хамгаалахын сайдын төсвийн багц дахь Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн эх үүсвэрээр санхүүжүүлж ажилласан. 2018 оноос улсын эдийн засаг, төсөвт эерэг өөрчлөлт гарч, Батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагааны зардалд улсын төсвөөс жил бүр 470-500 сая төгрөг батлагдаж байна. Түүнчлэн олон улсын хамтарсан сургууль, дадлага зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд холбогдон гарсан гадаад арга хэмжээний зардлыг Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн эх үүсвэрээс санхүүжүүлж байна.</p>

		1.8. Батлан хамгаалах салбарын хэмжээнд хүний нөөцийн бодлогыг сайжруулах, дотоод, гадаадын цэргийн их, дээд сургууль төгссөн боловсон хүчнийг оновчтой байршуулах, цаашид гадаадын цэргийн их, дээд сургуульд суралцуулах чиглэл, суралцагчдын тоо хэмжээг хүний нөөцийн бодлоготой уялдуулах арга хэмжээ авах;	Батлан хамгаалах тогтолцооны шинэчлэл, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх зорилтын хүрээнд Батлан хамгаалахын сайдын 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/70 дугаар тушаалаар “Батлан хамгаалахын хүний нөөцийн бодлого” баримт бичгийг батлуулсан. Тус баримт бичигт хүний нөөцийг төлөвлөх, бэлтгэх, байршуулах, хөгжүүлэх, удирдлага, хяналт гэсэн үндсэн 5 шаардлага, шалгуур үзүүлэлтийг тусгасан. Үүний дагуу дотоод, гадаадын цэргийн академи, их, дээд сургууль төгссөн боловсон хүчнийг Зэвсэгт хүчний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн эзэмшсэн мэргэжлийн дагуу анги, байгууллагад томилгоожуулан ажиллаж байна. Дээрх бодлогын баримт бичигтэй уялдуулан Батлан хамгаалахын сайдын 2020 оны дугаар тушаалаар “Хүний нөөцийн урт хугацааны төлөвлөгөө”-г батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
2	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2018.05.09 №05/13 /АБГББХ/ЭЗБХ/	1.5. Барилгын салбарт мөрдөгдөж байгаа норм, нормативын баримт бичгийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх талаар арга хэмжээ авах;	Барилга байгууламжийн норм, нормативын сангийн хөрөнгөөр 2019 онд техникийн зохицуулалтын баримт бичиг 3, барилгын норм ба дүрэм 25, барилгын болон техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал 52, стандарт 22-ыг тус тус шинээр болон шинэчлэн боловсруулсан байна.
3	Чиглэл өгөх тухай 2019.06.12 №03	1.1/в/ Монгол Улсын Засгийн газарт: Мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх хууль эрх зүйн орчныг судлан шаардлагатай бол энэ төрлийн гэмт хэрэгт хүлээлгэх ялын бодлогыг чангатгах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих эрх зүйн орчныг сайжруулах саналыг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгогүйгээр “олж авсан” үйлдлийг шинээр эрүүгийн гэмт хэрэгт тооцож, энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэхээр ялын бодлогыг чангаруулан Эрүүгийн хуульд тусгасан болно.
		1.1/г/ Мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох байгууллага болон	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/32 дугаар тушаалаар Хар тамхитай тэмцэх газрыг Эрүүгийн цагдаагийн албаны бүтцээс Тэргүүн дэд даргын шууд удирдлагад харьяалуулж, 33 алба хаагчийн орон тоотой, мөн даргын 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/16 дугаар тушаалаар орон тоог 46-аар нэмэгдүүлж, нийт 79 орон тоотой, албан тушаал, цол, цалингийн зэрэглэлийг баталсан.

		<p>холбогдох бусад байгууллагын хүн хүч, техникийг бэхжүүлэх, шаардлагатай бол уг гэмт хэрэгтэй тэмцэх бие даасан байгууллага байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх;</p>	
		<p>1.2/г/ Мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тамхи тээвэрлэх болон бусад хууль бус үйлдэл, хэрэг, зөрчилд нэр холбогдсон боловч одоо Дипломат төлөөлөгчийн газар ажиллаж байгаа албан тушаалтнуудыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эгүүлэн татах, хариуцлага хүлээлгэх;</p>	<p>2019 оны 3 дугаар улирлын байдлаар дипломат албанд ажиллах хугацаандаа мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодис, тамхи тээвэрлэсэн, мөн хууль бус бусад үйлдэл, хэрэг зөрчилд холбогдож байсан боловч дипломат албанд ажиллаж байсан дараахь хүмүүсийг дипломат албанаас халах, чөлөөлөх, эгүүлэн татах шийдвэрийг гаргасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Истанбул дахь Ерөнхий консулын газрын дэд консул Б.Баттүшиг; • Истанбул дахь Ерөнхий консулын газрын аж ахуйн эрхлэгч-жолооч С.Эрдэнэбаяр; • Гонгконг хот дахь Ерөнхий консул С.Эрдэнэ; • Вьентьян дахь Элчин сайдын яамны зөвлөх А.Батсайхан; • Европын газрын зөвлөх Х.Даваадорж; • Түүнчлэн өөрийн болон Ерөнхий консулын газрын нэр дээр Range Rover 1 ширхэг, Benz маркийн 3 ширхэг, нийт 4 автомашиныг суугаа орондоо импортоор оруулж, хятад иргэдэд дамлан худалдсан нь айлын талын эрх бүхий байгууллагын шалгалтаар тогтоогдсоны улмаас дипломат эрх ямба, дархан эрхийг нь цуцлах хүсэлтийг хятадын талаас албан ёсоор тавьсан тул Хөх хот дахь Ерөнхий консул Д.Мөнх-Эрдэнийг эгүүлэн татсан. <p>Польшийн цагдаагийн газрын эрэн сурвалжлах жагсаалтад байгаа Д.Энхбатыг өөрийнх нь хүсэлтээр дипломат албанаас чөлөөлсөн, Парис дахь Элчин сайдын яамны зөвлөх М.Батсайхан гэм буруугүй гэдгээ мэдэгдэж, өргөдөл гаргасан учраас гэм буруугүй гэдгээ нотолсон баримтаа гаргаж өгөх хүртэл албан тушаалаас нь түдгэлзүүлээд байна.</p> <p>“Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын хооронд байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ”-ний хүрээнд тус улсын Прокурорын газрын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 2019/94915 дугаартай хавтас хэрэгтэй холбогдуулан Истанбул дахь ЕКГ-ын гуравдугаар нарийн бичгийн дарга /суугаа орон консулаар зарласан/ Б.Энхмөнх, техник ажилтан Б.Алтансүх нараас мансууруулах бодис худалдаалах, гэмт хэрэг үйлдэх зорилготой байгуулагдсан байгууллагад гишүүнээр элсэх гэмт хэрэгтэй холбогдуулан байцаалт авах зөвшөөрөл хүссэн хүсэлтийг БНТУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-наас ноот бичгээр ирүүлсэн хүсэлтийг холбогдох журмын дагуу ХЗДХЯ-нд шилжүүлж, тус яамнаас хэргийг шалгаад зөвшөөрсөн хариу ирүүлсний дагуу Б.Энхмөнхийг нэр холбогдсон хэргээ эцэслэн шийдвэрлүүлэх хүртэлх хугацаанд үүрэг ажлаас нь түдгэлзүүлж, туркийн эрх бүхий байгууллагад байцаалт өгөх чиглэлийг Истанбул дахь ЕКГ-т хүргүүлээд байна.</p>

		<p>1.4/б/ Иргэдийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, үр дагаврын талаарх мэдээллээр хангах, энэ төрлийн гэмт хэрэгт холбогдох, ашиглагдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сэрэмжлүүлэх, таниулах арга хэмжээг зохион байгуулах.</p>	<p>Тайлангийн хугацаанд хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор аюулыг таниулах, урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн байгууллагаас 2-4 удаагийн давтамжтайгаар, нийт 4 удаагийн 150 минутын хугацаатай телевизийн нэвтрүүлэг, 3 удаагийн 70 минутын хугацаатай шууд нэвтрүүлэгт оролцож, телевизүүдэд давхардсан тоогоор 78 удаагийн 157 минутын сэрэмжлүүлэг мэдээлэл өгч, радиогийн нэвтрүүлэг 25 удаа, 210 минутын хугацаатай бэлтгэж, 48 минутын хугацаатай цаг үеийн холбогдолтой мэдээлэл, сэрэмжлүүлэг өгсөн. Дээрх санамж, сэрэмжлүүлгийг 4 пэйж хуудас болон zaluu.com, mass.mn зэрэг 15 мэдээллийн сайтад байршуулсан.</p>
Нийт 3 тогтоолын 9 заалт			

Танилцуулга бэлтгэсэн: ХШҮХ-ийн референт

Б.Энхмаа

